

МАЛ АЖ АХУЙН ТӨСӨЛ

Хугацаа: эхний шат – 2009-2011

Санхүүжүүлэгч байгууллага: ШХУ-ын Засгийн газар

Санхүүжилт: жилд 1,5 сая швейцари франк

Чиглэсэн аймаг: Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд, Баянхонгор, Архангай

Хариуцагч байгууллага: ХХААХҮЯ, СЯ



Үндэсний хөгжлийн стратеги 2008-2021 Үндсэн чиглэл:

- Малын өвчнүүдийг бүрэн хяналтандаа авах
- Мал аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх
- Газар тариалангийн эрчимжүүлсэн үйлдвэрлэлийг хөгжүүлэх,
- Нэмүү өртгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх
- Хүнсний аюулгүйн байдлыг хангах

Монгол Улсын Засгийн газраас ХАА-г хөгжүүлэх 2006 – 2015 оны стратеги (ХААХС) - д МАА-н чиглэлээр дараах тэргүүлэх зорилтуудыг тавьж буй. Үүнд:

- Малын ашиг шимийг дээшлүүлэх, бэлчээрийн тогтвортой менежмент
- Хүнс тэжээл, бэлчээр ашиглалт, үржил селекц голлон анхаарах
- Зах зээл, нэмүү өртөгийн сүлжээ, чанарын стандартыг боловсруулахад чухалчлан анхаарах
- Техникийн мэдлэгийг хүртээмжтэй болгоход чухалчлан анхаарах

Гадны хөрөнгө оруулалтыг татах тэргүүлэх чиглэлүүдийн хувьд ХААХС-д дараах таван чиглэлийг тодорхойлон тусгасан. Үүнд:

- ХАА-н (бэлчээрийн) ашиглалт
- Эрсдлийн менежмент
- Өвчний хяналт, онцгой үед авах арга хэмжээ
- Зах зээлийн харилцаа холбоог сайжруулах
- МАА-н менежмент болон үржил селекц



2007-2012 онд Монгол Улстай хэрэгжүүлэх Швейцарийн Хамтын ажиллагааны стратеги

•Малчдын түвшинд болон үндэсний хэмжээнд байгалийн нөөцийн менежмент, мониторингийн хяналтын эрх зүйн орчныг сайжруулах

Жендерийн асуудлыг харгалзсан, тэгш оролцоог хангахад чиглэсэн хууль тогтоомжийг боловсруулна; малчид газар эзэмших боломжтой болж; төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудын бодлогоо хэрэгжүүлэх чадавхи бэхжинэ.

•Мал аж ахуйн салбар дахь байгаль цаг уур зэрэг хүчин зүйлээс хамааралтай эмзэг байдлыг бууруулах, гамшгийн бэлэн байдал, байгаль орчны менежментийг сайжруулах

ХАА-н үйлдвэрлэл нэмэгдэж, газрыг нөхөн сэргээх явдал сайжирна; талхлагдсан газрыг өнжөөн ашиглах стратеги, төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ; малчдын амьжиргаа гамшгийн дараа ч баталгаатай хангагдсан байх нөхцлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

•Хөтөлбөрт хамрагдах бүс нутагт орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, малаас авах ашиг шимийг дээшлүүлсэнээр малчид, хөдөөгийн иргэдийн амьжиргааг сайжруулах

Зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх орон нутгийн нөөц, үйлчилгээ, ур чадварыг сайжруулна; бүсийн болон орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх үүсгэл санаачилгыг дэмжинэ; МАА-н менежмент, малчдад зориулсан үйлдвэрлэл, үйлчилгээг сайжруулна.

•Швейцарь, Монголын харилцааг бэхжүүлэх, засаглал, жендерийн тэгш байдал сайжруулах

Швейцарь, Монголын харилцаа, ардчилсан хөгжил, соёлын солилцоог гүнзгийрүүлэн хөгжүүлнэ.



МАА салбарын өмнө тулгарч буй бэрхшээлүүд

Бэлчээрийн тогтвортой менежментийг нэвтрүүлэх: "нийтийн эзэмшлийн бэлчээрт хувийн мал бэлчээрлүүлэх"-тэй холбоотой асуудлыг шийдвэрлэх, өөрөөр хэлбэл бэлчээр талхлагдах, муудах, цөлжих явдлыг зогсоох, сэргийлэх

МАА-н үйлдвэрлэлийн тогтолцооны өгөөж, эдийн засгийн ашгийг дээшлүүлэх: малын тэжээл, эрүүл мэнд, үүлдэр угсааг сайжруулах, сүргийн менежмент, борлуулалт, түүнчлэн нэмүү өртөг шингээх явдлыг нэгтгэх

Бруцеллёз, хөл, амны өвчин, сүрьеэ, цусны лейкоз болон бусад халварт өвчний дэгдэлт, тархалтыг хязгаарлаж, малын өвчлөх эрсдлийг бууруулж, мах экспортлох боломжийг сайжруулах

Мал эмнэлгийн тогтолцоогоор дамжуулан малчдыг мал эмнэлгийн чанартай үйлчилгээ, эмээр хангах. Шимэгчдийг устгах дотоодын 12 бүтээгдэхүүний зөвхөн ганц нь зохих идэвхтэй бодис агуулсан байсныг ШХА-ийн мал эмнэлгийн лабораторийг сайжруулах төсөл харуулсан.

Малын тоо толгойг нэмэгдүүлэх гэхээсээ нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх зарчмыг нэг малын хувьд ч, сүргийн хувьд ч баримталдаг болох

Бэлчээрийн болон маллагааны прагматик, бодитой бодлого боловсруулж хэрэгжүүлэх, үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө боловсруулах, эдгээр асуудлаар хэрэгжүүлж буй олон төсөл, хөтөлбөрүүдийг уялдуулан зохицуулах



МАЛ АЖ АХУЙН ТӨСӨЛ

Ерөнхий зорилго: Малчдын амьжиргааг баталгаажуулах, орлогыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах

Эхний шатны зорилт /2009-2011/: “Төслийг хэрэгжүүлэх үр дүнтэй механизм бүрдүүлэн, төслийн чиглэгдсэн бүс нутгийн малчин өрхүүдийн малын ашиг шим өсч, МАА-н бүтээгдэхүүний нэмүү өртгийн үйлдвэрлэл болон орлого нэмэгдэж буйн эхний нааштай үр дүнг харуулах”

Малын эрүүл мэнд, сүргийн менежментийн талаархи малчид, малын эмч нарын ур чадварыг дээшлүүлж, нэмүү өртөгийн үйлдвэрлэл, борлуулалтын салбарт уялдаатай хамтын ажиллагааг бий болгохыг эрэлхийлэх нь малчин өрхүүдийн, нэн тэргүүнд цөөн малтай өрхүүдийн, эмэгтэйчүүдийн эдийн засгийн байдлыг мэдэгдэхүйц дээшлүүлэх болно.

Мал аж ахуйн төсөл нь малын ашиг шимийг дээшлүүлж, малын гаралтай бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингээх, малчдын амьжиргааг сайжруулахад бодитой хувь нэмэр оруулахад чиглэгдэх юм. Уг төслийн үзэл санаа Үндэсний хөгжлийн стратеги болон Монгол улсад хэрэгжүүлэх Швейцарийн хамтын ажиллагааны 2007-2012 оны стратегид нийцсэн болно.



МАЛ АЖ АХУЙН ТӨСӨЛ

4 бүрэлдэхүүн хэсэгтэй:

1. Мал эмнэлгийн үйлчилгээ
2. Бруцелёзын бүрэлдэхүүн хэсэг
3. Сарлаг, тэмээний гаралтай бүтээгдэхүүн
4. Уялдаа зохицуулалт, мэдлэгийн менежмент болон чадавхийг бэхжүүлэх бүрэлдэхүүн хэсэг

Гол түншүүд:

- ХХААХҮ-ийн яам
- Эрүүл мэндийн яам
- Мал эмнэлгийн хүрээлэн
- Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори
- ХААИС, Мал эмнэлэг, биотехнологийн сургууль
- Халдварт өвчин судлалын үндэсний төв
- Европын Холбооны “Малын эрүүл мэнд, мал аж ахуйн зах зээл төсөл”
- Мерси Кор
- Швейцарийн ХАА-н коллеж

Мал аж ахуйн төслийн бүрэлдэхүүн хэсгүүд ба гарах үр дүн

Бүрэлдэхүүн хэсгүүд

Мал эмнэлгийн үйлчилгээний бүрэлдэхүүн хэсэг:	Бруцелёзын бүрэлдэхүүн хэсэг:	Сарлаг, тэмээний бүрэлдэхүүн хэсэг:	Уялдаа зохицуулалт, мэдлэгийн менежмент болон чадавхийг бэхжүүлэх бүрэлдэхүүн хэсэг:
--	--------------------------------------	--	---

Хүрэх үр дүнгүүд

Малын эмч, малчин өрхүүдийн МАА –н менежментийн ур чадвар дээшилнэ.	Бруцелёзыг устгах үндэсний хөтөлбөрийн үндсэн хэсгүүдийг боловсруулж туршина.	Сарлаг, тэмээний бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингээх сүлжээ бий болж өргөжинө.	ХАА-н салбарт гадны санхүүжилтээр хэрэгжүүлж буй төслүүдийн үр дүн, өгөөж нэмэгдэнэ.
---	---	--	--

Хамтран хэрэгжүүлэгч байгууллагууд

Монгол В.Е.Т. Нэт ТББ, Мерси Кор, Дэлхийн зөн, Самаританс Пөрч, ЭмСиЭйч	ХХААХҮЯ, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори, Мал эмнэлэг, үржлийн газар, Европын холбоо	Монгол сарлаг нийгэмлэг, Монгол тэмээ нийгэмлэг, Швейцарийн Хөдөө аж ахуйн коллеж	ХХААХҮЯ, бэлчээр, мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бусад хандивлагч орнуудын төсөл, хөтөлбөрүүд, төрийн болон ТББ
---	--	---	--

Төслийн менежмент



